



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуунхороот сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/97/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
2021 он	Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
	Аудитын менежер: И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Аудитор: Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 314
танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.АЛТАНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Чулуунхороот сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Чулуунхороот сумын соёлын төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 80 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020310

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,337,369.50	13,297,609.70
33	АВЛАГА	21,499.50	885,149.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		885,149.70
35	БАРАА МАТЕРИАЛ	11,315,870.00	12,412,460.00
354	Хангамжийн материал	11,315,870.00	12,412,460.00
35410	Бичиг хэргийн материал	-	91,000.00
35420	Аж ахуйн материал	11,042,190.00	12,103,660.00
35440	Түлш, шатах тослох материал	273,680.00	217,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	326,359,090.91	411,433,045.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	326,359,090.91	411,433,045.07
392	Биет хөрөнгө	324,127,090.91	409,201,045.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	286,551,121.91	365,185,848.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,187,174.96)	(16,374,349.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,775,058.00	40,310,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,729,786.62)	(11,648,759.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,746,148.40	43,761,451.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,357,685.82)	(27,362,555.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,329,410.00	15,329,410.00
393	Биет бус хөрөнгө	2,232,000.00	2,232,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,232,000.00	2,232,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	337,696,460.41	424,730,654.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	885,149.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	885,149.70
413	Өглөг	-	885,149.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		885,149.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	337,696,460.41	423,845,505.07
51	Засгийн газрын хувь оролцоо	337,696,460.41	423,845,505.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,728,402.40	189,728,402.40
51101	Өмч - төрийн	187,496,402.40	187,496,402.40
51102	- хувийн	2,232,000.00	2,232,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(85,953,928.46)	195,116.20
51210	Өмнөх үеийн үр дүн	(79,597,685.61)	(85,953,928.46)
51220	Тайлант үеийн үр дүн	(6,356,242.85)	86,149,044.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	233,921,986.47	233,921,986.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	337,696,460.41	424,730,654.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	71,222,480.00	193,485,027.00
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,222,480.00	193,485,027.00
1310	Удсын төвлөрсөн төсвөөс	69,692,680.00	192,751,027.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	62,148,100.00	82,117,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	7,544,580.00	110,634,027.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,529,800.00	734,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд өнгө болсон	1,529,800.00	734,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	77,578,722.85	102,239,449.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,578,722.85	102,239,449.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,213,317.15	102,076,050.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,029,994.23	61,594,551.90
210101	Үндсэн цалин	39,003,973.23	51,225,848.95
210105	Гэрээт ажлын хөлс	6,026,021.00	10,368,702.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,401,148.17	8,061,133.13
210201	Тэтгэврийн даатгал	3,395,693.54	5,678,433.13
210202	Тэтгэмжийн даатгал	723,204.95	595,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,711.00	476,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	85,195.68	119,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	827,343.00	1,191,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,899,834.40	9,196,115.00
210301	Гэрэл, цахилгаан	1,776,093.90	1,353,121.00
210302	Түши, халаалт	7,123,740.50	7,842,994.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,172,900.00	4,497,461.00
210401	Бичиг хэрэг	261,950.00	340,779.00
210402	Тээвэр, шатахуун	320,450.00	521,152.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгдэх, ахуйн эд зүйлс	120,000.00	203,700.00
210408	Бараа материал ахалсны зардал	1,470,500.00	3,231,830.00
2106	Эл хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,400,070.00	1,030,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,240,070.00	850,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,045,370.35	17,196,239.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,045,370.35	17,196,239.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	365,405.70	163,398.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	365,405.70	163,398.47
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	365,405.70	163,398.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,356,242.85)	91,245,577.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,096,532.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,096,532.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,096,532.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,356,242.85)	86,149,044.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

0	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	63,677,900.00	82,851,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63,677,900.00	82,851,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	62,148,100.00	82,117,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	62,148,100.00	82,117,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,529,800.00	734,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,529,800.00	734,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	63,677,900.00	82,851,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,677,900.00	82,851,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,312,494.30	82,687,601.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,051,493.73	61,573,052.40
210101	Үндсэн цалин	39,025,472.73	51,204,349.45
210105	Гэрээт ажлын хөлс	6,026,021.00	10,368,702.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,388,556.17	8,061,133.13
210201	Тэтгэврийн даатгал	3,395,693.54	5,678,433.13
210202	Тэтгэмжийн даатгал	723,204.95	595,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,119.00	476,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	85,195.68	119,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	827,343.00	1,191,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,831,414.40	8,706,235.00
210301	Гэрэл, цахилгаан	1,776,093.90	1,353,121.00
210302	Түлш, халаалт	7,055,320.50	7,353,114.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,502,400.00	1,356,631.00
210401	Бичиг хэрэг	261,950.00	431,779.00
210402	Тээвэр, шатахуун	320,450.00	521,152.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	920,000.00	203,700.00
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	-
210702	Дотоод албан томилолт	264,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,274,630.00	1,030,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,114,630.00	700,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	180,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	365,405.70	163,398.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	365,405.70	163,398.47
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	365,405.70	163,398.47
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	-85,953,928.46	0.00	337,696,460.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	-85,953,928.46	0.00	337,696,460.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	-85,953,928.46	0.00	337,696,460.41
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	-85,953,928.46	0.00	337,696,460.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	-85,953,928.46	0.00	337,696,460.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	86,149,044.66	0.00	86,149,044.66
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,728,402.40	233,921,986.47	195,116.20	0.00	423,845,505.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	81,953,601.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	81,953,601.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	81,953,601.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,156,400.00	45,051,493.73	61,581,800.00	61,573,052.40
210101	Үндсэн цалин	39,097,200.00	39,025,472.73	51,366,900.00	51,204,349.45
210105	Гэрээт ажлын хөлс	6,059,200.00	6,026,021.00	10,214,900.00	10,368,702.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,644,300.00	5,388,556.17	8,172,200.00	8,061,133.13
210201	Тэтгэврийн даатгал	3,838,000.00	3,395,693.54	5,788,900.00	5,678,433.13
210202	Тэтгэмжийн даатгал	451,400.00	723,204.95	595,800.00	595,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	361,500.00	357,119.00	476,700.00	476,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	89,900.00	85,195.68	119,200.00	119,200.00
210205	Эрүүд мэндийн даатгал	903,500.00	827,343.00	1,191,600.00	1,191,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,836,000.00	8,831,413.50	8,719,300.00	8,706,235.00
210301	Гэрэл, цахилгаан	1,850,000.00	1,776,093.00	1,353,300.00	1,353,121.00
210302	Түлш, халаалт	6,986,000.00	7,055,320.50	7,366,000.00	7,353,114.00
2104	Хангамж, бараа материалын зардал	587,400.00	587,400.00	1,356,800.00	1,356,631.00
210401	Бичиг хэрэг	187,900.00	186,950.00	431,900.00	431,779.00
210402	Тээвэр, шатахуун	319,500.00	320,450.00	521,200.00	521,152.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,000.00	80,000.00	203,700.00	203,700.00
2105	Нормативт зардал	-	-	620,000.00	620,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	620,000.00	620,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	906,900.00	906,000.00
210602	Тавилга	-	-	406,900.00	406,000.00
210604	Урсгал засвар	-	-	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,660,000.00	1,659,830.00	760,000.00	730,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,499,830.00	430,000.00	400,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	180,000.00	180,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	150,000.00	150,000.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	82,117,000.00
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	82,117,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	62,148,100.00	61,782,693.40	82,117,000.00	82,117,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	734,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	734,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	734,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	0.00	300,000.00
210801	бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	-	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	434,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	434,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	734,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	734,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	734,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Алтанчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Чулуунхороот сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чулуунхороот сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Соёлын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чулуунхороот сумын Соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Чулуунхороот сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 107,336.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 2,147.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чулуунхороот сумын Соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,034.2 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	21.4	885.1	863.7
Бараа материал	11,315.9	12,412.5	1,096.6
Үндсэн хөрөнгө	369,633.7	466,818.7	97,185.0
Хуримтлагдсан элэгдэл	(43,274.6)	(55,385.7)	(12,111.0)
Нийт хөрөнгө	337,696.4	424,730.6	87,034.2
Өр төлбөр	-	885.1-	885.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	337,696.4	423,845.5	86,149.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	337,696.4	424,730.6	87,034.2

Авлагын үлдэгдэл 885.1 мянган төгрөг болж, 863.7 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ХХОАТ суутгахгүй байх хуулийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,412.6 мянган төгрөг болж 1,096.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны худалдан авалтаас үлдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 466,818.7 мянган төгрөг болж 97,185.0 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 78,634.7 мянган төгрөгийн барилгын сайжруулалт, 22,905.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 11,008.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, хөгжмийн зэмсгийг хандиваар хүлээн авснаар нэмэгдсэн байна.

ИТХ-ын шийдвэрээр 10,181.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 885.1 мянган төгрөг болж 885.1 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад өгөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 423,845.5 мянган төгрөг болж 86,149.1 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө орлого авснаас шалтгаалжээ.

Чулуунхороот сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 122,262.5 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 24,660.7 мянган төгрөгөөр буюу 32.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 82,117.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 82,117.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 82,117.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 82,117.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 82,117.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 734.0 нийт 82,851.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 82,687.6 мянган төгрөгийг зарцуулж 163.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 82,687.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 69,634.2 мянган төгрөг буюу нийт зардлын 84.2 хувийг эзэлж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт үйл ажиллагаанаас 734.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,046.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,046.7 мянган төгрөгийн зөрчилд 31.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт 1 тогтоож, 13,015.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлжээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 13,046.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,046.7 мянган төгрөгийн зөрчилд 31.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт 1 тогтоож, 13,015.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 31.4 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого нь дэлгэрэнгүй бүртгэл дэх дүнтэй тулгахад номын тооллого хийсэн баримтгүй 8,784.9 мянган төгрөгийн номыг багцаар бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2 дахь “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн нүүрс тээврийн зардалд 3,260.4 мянган төгрөг зарцуулсан боловч холбогдох анхан шатны баримт гэрээг хийгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн “41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, бодит байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 970.0 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод аймгийн Чулуунхороотын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/97/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Чулуунхороотын соёлын төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч Номын тооллогыг нэг бүрчлэн жагсаалтаар тооллого хийсэн баримт байхгүй. Бүртгэлд тусгахдаа 1ширхэг ном 6,823,3 төгрөг, 1 ширхэг ном 1,961.6 мянган төгрөгөөр бөөн дүнгээр орлого авсан байна.	8,784.9	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Алтанчимэг, Т.Энхзул
2	Нийт 135 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр 4 сард) 1 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр 4 сард) 1 мэдээлэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр 10 сард), Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр 10 сард) , Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр 10 сард) , Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр 4 сард), Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр		Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Алтанчимэг, Т.Энхзул

	(Тухай бүр 4 ба 12 сард), Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр), Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр), Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр 11 сард), Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр 4 сард) зэрэг 12 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.				
3	Нүүрс тээвэрлэх, ажлын хөлс олгох гэрээ байхгүй 180 тонн нүүрс 3,260.4 мянган төгрөгөөр худалдан авсан. Тээврийн хөлс 1,007.8 мянган төгрөг. 10 тонн нүүрс нэмэлт данснаас 434.0 мянган төгрөг зарцуулалт хийж ажилчдадаа олгосон..	3,260.4	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Алтанчимэг, Т.Энхзул
4	Харилцахаас 12,518.1 мянган төгрөгийн зардал төлөгдсөнөөс баримт татварын цахим системд 970,0 мянган төгрөгийн баримт бүртгэгдээгүй байна.	970.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Алтанчимэг, Т.Энхзул
5	Батлагдсан төсөв 521,2 мянган төгрөг, Зарцуулалт хэтрээгүй ч, жишиг нормоор тооцоолоход 31,4 мянган төгрөгийн илүү зарцуулалттай.	31.4	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Д.Алтанчимэг, Т.Энхзул
ДҮН		13,046.7			